



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус компани Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин 69,2 сая төгрөгийн ажил гүйлгээг бүрдэл дутуу баримтаар хийсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2, 21 дүгээр зүйлийн 21.4, 27 дугаар зүйлийн 27.1.1, 44 дүгээр зүйлийн 44.2, 44.4, 52 дугаар зүйлийн 52.1.12, Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалын 2-т заасныг тус тус зөрчин 2017 онд 209,1 сая төгрөгийн, 2018 онд 238.6 сая төгрөгийн худалдан авалтыг зохин байгуулсан зэрэг нийт 516,8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Гантуулд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх, зөрчлийг арилгах;

2.2. Томилолтыг байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу олгох, ажлын 5 хоногийн дотор ажлын үр дүнгийн тайланг хүлээн авч, удирдлагаар дүгнүүлэн, тамга, тэмдгээр баталгаажуулсны дараа тооцоог хааж байх;

2.3. Оршин суугч ахуйн хэрэглэгч, аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагын бүртгэлийн системийг сайжруулах, боловсронгуй болгох;

2.4. “Зенит норт стар пропертиз” ХХК-тай холбоотой 2014 онд үүссэн 19,1 сая төгрөгийн авлагыг барагдуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

2.5. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

0000269

2.6. Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулах гэрээнд хөрөнгийн баталгаат хугацааны барьцаа авах, алданги, торгууль тооцох, урьдчилгаа төлбөр олгох заалт оруулах, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, гэрээ хариуцсан ажилтны ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх;

2.7. Гэрээт ажлын санхүүжилт олгохдоо гүйцэтгэлтэй нь уялдуулан авч үзэх;

2.8. Байгууллагын бүртгэл, санхүү, инженер техник, төсөв хариуцсан ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах;

2.9. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн  
22 дугаар тогтоолын хавсралт



“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат  
компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг  
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /мянган төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Албан томилолттой холбоотой гарсан зөрчлийн талаар	2017-2018 он	14,826.40	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах, ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх.
2	Тушаал шийдвэр, үндсэн баримтгүй ажил, үйлчилгээний талаар	2017-2018 он	54,368.40	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах, ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх.
3	Тендерийн жишиг баримт бичгийг боловсруулалгүй тендер шалгаруулалт явуулсан талаар	2017-2018 он	348,404.84	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалын 2 дахь заалт	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах.
4	Тендерийн баримт бичигт тусгасан ерөнхий нөхцлийг хангаагүй, татварын өртэй бэлтгэн нийлүүлэгчийг шалгаруулсан талаар	2017-2018 он	99,289.50	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, 52.1.12-т, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсэг	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах.
<b>НИЙТ ДҮН:</b>			<b>516,889.14</b>		